

**УНТЭ-Т СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭНИЙ ТАСАГТ ИХ ЭМЧ
АЖЛЫН БАЙРНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА.**

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:

1. Сэргээн засах эмчилгээний төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх
2. Яаралтай тусламж, үйлчилгээг үзүүлэх
3. Эмчилгээ үйлчилгээний шинэ арга техникийг нэвтрүүлэн ажиллах
4. Эмчилгээний үр дүнг тооцох, судалгаа дүгнэлт хийж ажиллах

Тавигдах шаардлага:

1. Анагаах ухааны их дээд сургуулийг хүний их эмчийн мэргэжлээр төгссөн байх
2. Эмчлэх эрхийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх
3. Сэргээн засах, нөхөн сэргээх эмчилгээний чиглэлээр мэргэшсэн, мэргэжил дээшлүүлсэн байх
4. Эрдмийн болон мэргэжлийн зэрэгтэй байх
5. Төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан ажлын дадлага туршлагатай байх
6. Англи хэлний зохих түвшний мэдлэгтэй байх
7. Эерэг харилцаа хандлагатай, багаар ажиллах чадвартай
8. Дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх ур чадвартай байх;

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн 1-р маягт /3*4 цээж зураг-2%/
- Боловсролын түвшинг тодорхойлсон бүх баримт бичгүүд /нотариатаар гэрчлүүлсэн байх/
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа
- Ажилд орохыг хүссэн өргөдөл

Дээрх шаардлагыг бүрэн хангасан материалыг УНТЭ-ийн Захиргаа, хүний нөөцийн албанд 2025.12.25-ны өдрийг дуустал хугацаанд хүлээн авна. Утас:77111017

Сонгон шалгаруулалтыг дараах байдлаар зохион явуулна. Үүнд:

1. Баримт бичгийн шалгаруулалт
2. Ярилцлагын шалгалт